

МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/223

Зуунмод

Газар өмчлүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, 29.2, Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6.1, 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төв аймгийн Зуунмод сумын Номт 1-р баг, Хуульчдын хотхон 126 тоот хаягт 4110061377 нэгж талбарын дугаартай 300 метр квадрат газрыг иргэн Дашдаваагийн Атарцэцэг /НТ81102300/-д 8.450.000 /Найман сая дөрвөн зуун тавин мянган/ төгрөгөөр худалдаж өмчлүүлсүгэй.

2.Газар өмчлөгч иргэн Д.Атарцэцэгт доорх зүйлийг үүрэг болгосугай.

2.1.Газрыг кадастрын мэдээллийн санд бүртгүүлж, баталгаажуулах.

2.2.Газрыг үл хөдлөх, эд хөрөнгийн бүртгэлд бүртгүүлж гэрчилгээжүүлэх

2.3.Газрын төлөв байдал, чанарыг доройтуулахгүй байх.

3.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар/М.Отгонбат/, Улсын бүртгэлийн хэлтэс /Н.Энхбат/ нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Ж.БАТЖАРГАЛ



01 000582